

**АЙМГИЙН ХЭМЖЭЭНД АХУЙН ЗОРИУЛАЛТААР АГНАХ, БАРИХ
ЗАГАСНЫ АГНУУРЫН БҮС ТОГТООЖ, НАРИЙВЧИЛСАН АГНУУР
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР / ТЕХНИКИЙН
ТОДОРХОЙЛОЛТ/**

“Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт ахуйн зориулалтаар агнах, барих загасаны агнуурын бүс тогтоож, нарийвчилсан агнуур зохион байгуулалт хийх, ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулан батлуулах” ажлын даалгавар

Нэг. Үндэслэл

“Амьтны тухай” Монгол Улсын хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т аймаг, сумын Засаг дарга нар харьяалах нутаг дэвсгэрт агнуур зохион байгуулалтыг 5 жил тутам хийлгэж байхаар заасан байна. Агнуур зохион байгуулалтыг дараахь 2 төрөлд ангилна.

1. Ерөнхий агнуур зохион байгуулалт
2. Нарийвчилсан агнуур зохион байгуулалт

Ерөнхий агнуур зохион байгуулалтыг аймгийн нутаг дэвсгэрт хийх бөгөөд ан амьтны тархац нутаг, биологийн болон агнуурын нөөц, агнуурын амьтны нас, хүйсний бүтэц, нөхөн үржлийн чадавхийг судалсны үндсэн дээр агнуурын бүс нутгийн хилийн зааг, хэмжээг тогтоож, ан агнуурын менежментийн төлөвлөгөөний төсөл боловсруулж БОАЖЯаманд батлуулна.

Нарийвчилсан агнуур зохион байгуулалтыг сум, аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөлийн хариуцан хамгаалж байгаа газар нутагт хийнэ. Агнуурын бүс нутаг дахь ашиглаж болох агнуурын амьтны төрөл, тоо хэмжээг тогтоож, ан агнуурын менежментийн төлөвлөгөөний төсөл боловсруулна.

Хоёр. Гүцэтгэх ажил:

Монгол улсын Засгийн газрын 19 дүгээр тогтоолыг мөрдөн ажиллах.

1. Загасны төрөл, зүйл, тархац нутаг, биологийн болон агнуурын нөөц, агнуурын загасны нас, хүйсний бүтэц, нөхөн үржлийн чадавхийг судлан тогтоож,

Ховд гол-8, Сагсайн гол-2 Толбо нуур-1 Тал нуур-1ахуйн зориулалтаар загас агнах, барих агнуурын бүс тогтоож, загас агнуурын бүс нутгийн агнуур зохион байгуулалтын тайлан, агнуурын менежментийн төлөвлөгөөг бичлэг, CD-тэй хамт БОАЖГ-т хүлээлгэн өгөх. БОАЖГ-ын амьтны асуудал хариуцсан мэргэжилтэн болон сумдын БОХУБайцаагч, байгаль хамгаалагч нарыг оролцуулах /ажилласан албан хаагчдын албан томилолт, унааны зардлыг хариуцах/.

2. Нарийвчилсан агнуур зохион байгуулалт хийх нийт талбайн 80-аас доошгүй хувьд нь сорилын талбайг сонгож авах ажлыг гүйцэтгэх.
3. ахуйн зориулалтын загас агнуурын бүс нутгийн агнуур зохион байгуулалтын тайланг үндэслэн загасны тархалтын зураг боловсруулсан агнуурын бүс нутгийг сум бүрээр тогтоож өгөх.
4. Ахуйн зориулалтын загас агнуурын бүс нутгийн агнуур зохион байгуулалтын тайлан, агнуурын менежментийн төлөвлөгөөг аймгийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагаар хянуулан батлуулах.
5. Загасны зүйлийн ялгах гэрэл зураг, таних шинж тэмдэг, нас хүйсийн онцлог, амьдрах орчин, нүүдэл, идэш тэжээл, тархалтыг тодорхой тусгасан мэдээг цахим /CD/ хэлбэрээр олшруулж албан хэрэгцээнд ашиглах боломжтойгоор хүлээлгэн өгөх, материалаар хангах.

Зурв. Гарах үр дүн

- Сум бүр загас агнуурын менежментийн төлөвлөгөөний дагуу ажиллах болно.
- Загасны тархалтын зураг агнуурын бүс нутгийн тогтоосон зурагтай болно.
- Агнуурын загас ашиглаж болох төрөл, тоо хэмжээний дээд хязгаарыг тогтоосон хуваарийн дагуу ажиллах болно.
- Ахуйн зориулалтын загас агнуурын бүс нутгийн агнуур зохион байгуулалтын тайлан, агнуурын менежментийн төлөвлөгөөгтэй болно.

Дөрөв. Тайлан

Ажил гүйцэтгэгч “ахуйн зориулалтын загас агнуурын бүс нутгийн агнуур зохион байгуулалтын тайлан, агнуурын менежментийн төлөвлөгөөг тархалтын зураг, загасны судалгааны тайланг гаргаж хэрэгцээг баталсан хуваарь”-ийн хамт файлаар болон бичмлээр аймгийн БОАЖГ-т гаргаж хүлээлгэн өгнө.

Тав. Мэргэжлийн шаардлага:

Агнуур зохион байгуулалт хийх мэргэжлийн байгууллага нь дараах мэргэжлийн шаардлагагыг хангасан байна. Үүнд:

1. БОАЖЯамнаас агнуур зохион байгуулалтын эрх авсан мэргэжлийн байгууллага байх.
2. Мэргэжилтнүүд нь амьтан судлал, загас судлал, агнуур зүйн чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан, магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой:
3. Агнуур зохион байгуулалтын ажил хийж байсан туршлагатай эрдэмтэн, судлаач, мэргэжилтэнтэй байх:
4. Компьютер, техник тоног төхөөрөмж, программ хангамжийн хангагдсан, агнуур зохион байгуулалттай холбоотой арга зүйг эзэмшсэн байх.

Зургаа. Хийх хугацаа

2023 оны 11 сар-12 сар

Тендер зарлах хугацаа 1-р сард багтаан

Гаргасан: Байгаль орчин, аялал жуулчлалын газар